

10

ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЛААРХИ ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Я.Отгонсүрэн, М.Булгантамир

Abstract

Educational market is one of the movable markets to change following social and economic development of the country within defined period.

We got the research of elementary level for marketing from basic five resources such as employers, learners, teachers as well as parents in order to define main factors and competitive capacity of universities and institutes of Mongolia according to research methods of “Test” and evolution indication of customers and we decide to express result of the research in the article.

Key words

Higher educational organization, competitive capacity, quality of teaching, influencing factors of quality of teaching

Үндсэн хэсэг

Хүн төрөлхтөн мэдлэгийн зуунд шилжиж, мэдлэг нь хувь хүнийг төдийгүй улс орныг хөгжүүлэх гол хэрэгсэл болж байгаа өнөөгийн нөхцөлд орчин үеийн боловсролын хөгжил, шинэчлэлтийн үзэл баримтлалыг дэлхийн жишигт нийцүүлэн, өөрийн орны онцлогт тохируулан өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Дэлхийн улс орнууд боловсролынхоо тогтолцоог хөгжүүлэх түүний хүртээмж, чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон талын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд өнөө үед боловсролын хөгжлийн асуудал дан ганц нэг улс үндэстний биш тив, бүс нутаг, цаашлаад дэлхийн хэмжээнд яригдах болж бие биенээсээ харилцан хамааралтай болжээ.

Дээд боловсрол нь харилцан хамаарал бүхий ОРЦ-ЯВЦ-ГАРЦ-ын тогтолцоо бүхий олон олон хүчин зүйлийг багтаасан нэгдсэн систем бөгөөд нийгмийн тогтолцооны амин чухал нэг хэсэг түүнийг хөдөлгөгч гол хүч юм. Дээд боловсролыг эзэмших хэрэгцээ шаардлага нь нийгмийн

болон хувь хүний эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдож байна. Энэ утгаараа боловсролын үүрэг зорилгыг хүний оршин ахуйн боломжийг нэмэгдүүлэх талаас нь авч үзэх хэрэгтэй. Түүнчлэн боловсролын зорилго нь нийгэм, хувь хүн, оролцогч талуудын бодит хэрэгцээ шаардлагаас урган гарах бөгөөд түүхэн үе бүрд өөр өөрийн гэсэн хөгжлийн чиг хандлагыг агуулсаар ирсэн юм.

Аливаа байгууллага, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөөн гэдэг нь хэрэглэгчийн эрэлтийг өөрийн давуу талаар хангаж, тэдний сонголтонд өөрийн бараа үйлчилгээг хоногшуулах явдлыг ойлгох бөгөөд тэрхүү ялгаатай давуу талуудыг өрсөлдөх чадварын үзүүлэлт гэж үзэж болно. Зах зээлийн хүрээний бүх субъектууд өөрийн гэсэн хүчтэй өрсөлдөөнтэй байгаа өнөөгийн нөхцөлд дээд боловсролын байгууллагууд мөн адил бага зардлаар чанартай сургалт явуулах, мэргэжил эзэмшүүлэхийн төлөө боловсролын зах зээлд өрсөлдөж байна. Боловсролын зах зээл нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг даган түргэн өөрчлөгдөж байдаг хамгийн хөдөлгөөнтэй зах зээл байдаг. Энэ учир Монголд үйл ажиллагаа явуулж буй их дээд сургуулиудын сургалтын чанарын тухай асуудал нь тэдний өрсөлдөх чадварыг тодорхойлох гол хүчин зүйл гэж үзэж бид энэхүү анхдагч судалгааг төгсөгчид, ажил олгогчид, суралцагчид, багш нар, эцэг эх гэсэн үндсэн таван эх үүсвэрээс авч, “Т”тестийн, Хэрэглэгчдийн үнэлгээний индексийн аргаар боловсруулалт хийж, дүгнэлт хийхийг зорьсон юм.

Судалгааг илүү бодитой болгох үүднээс эдийн засаг, бизнесийн удирдлага, багшлах боловсон хүчин бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургуулиуд, энэ чиглэлээр төгссөн мэргэжилтнүүд, оюутан залуус, тэдний эцэг эх гэсэн эх үүсвэрээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан. Санал асуулгын хуудсыг тус бүр 1050 ширхэгийг боловсруулан тараасан ба хүчинтэй 800 хуудсыг ялган судалгааны үр дүнг гаргалаа. Ажил олгогчид болон бизнес эрхлэгчдээс авах санал асуулгыг 350 хувь хэвлэж тарааснаас хүчинтэй 300 хариултыг судалгаанд ашигласан. Ингэхдээ ихэвчлэн хүний нөөцийн менежер, дунд болон дээд шатны менежерүүдээс судалгааг авахыг зорьсон болно. Их дээд сургуулийн багш нараас авах санал асуулгын хуудсыг 382 хувь тараан, төрийн болон хувийн хэвшлийн 67 сургуулийн багш, тэнхмийн эрхлэгч, сургалтын менежерүүдийг хамруулсан ба эдгээрээс мөн 300 ширхэг хүчинтэй хуудсыг үндэслэн тооцоог хийсэн.


Судалгаанд хамрагдагсдыг орон нутгийн харьяалалаар нь авч үзвэл 40% нь орон нутгийн, 60% нь суурин газрын буюу Улаанбаатар, Эрдэнэт Дархан хотын элсэгчид, тэдгээрийн эцэг эх нар байв. Сургуулийн удирдах ажилтан албан хаагчид, багш нарын 33% нь төрийн өмчийн, 64% нь хувийн, 3% нь гадаадын хөрөнгө оруулалттай их дээд сургуулийн багш нар, харин төгсөгчдийн 30 хувь нь улсын, 45% нь хувийн хэвшлийн, 7% нь гадаадын хөрөнгө оруулалттай их дээд сургууль, 19 хувь нь гадаадад боловсрол эзэмшигч байсан. Суралцагчдын хувьд 32 % нь төрийн өмчийн,

68 хувь нь хувийн хэвшлийн сургуульд суралцдаг оюутан залуус хамрагдлаа.

Төгсөгчид, ажил олгогчид, оюутан суралцагчид, элсэгчдийн эцэг эх, сургуулийн удирдлагаас авсан судалгаанд “Таны бодлоор сургуулийн өрсөлдөх чадварыг тодорхойлдог хамгийн чухал гэж үзсэн элементүүдийг нэрлэнэ үү” гэсэн асуултанд судалгаанд оролцогсад 100 хувь *сургалтын чанар сайн байх* гэдэг үзүүлэлтийг чухалд тооцсон. Сургалтын чанар гэсэн хариултыг хэрэглэгчийн үнэлгээний индексээр үнэлбэл хамгийн өндөр буюу 4,32 гэсэн үнэлгээ авсан. Өөрөөр хэлбэл өрсөлдөх чадварыг тодорхойлох хамгийн гол үзүүлэлт бол сургалтын чанар байв.

Мөн судалгаанд оролцогсад багшлах боловсон хүчний чадвар, сургалтын тав тухтай орчин нөхцлийг сурлагын чанартай ач холбогдолоороо эн тэнцэхүйц өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд хэмээн үзсэн. /Зураг 1/

Өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг тодорхойлох анхдагч судалгааны дүн



Эх сурвалж: Анхдагч судалгааны үр дүнг “Т” тестийн аргыг ашиглан тооцоолсноор

Манай орны өнөөгийн дээд боловсролын чанарт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 25% нь сайн, 47% нь дунд, 19 % нь муу, харин 9% нь дүгнэж чадахгүй нь гэсэн хариултыг өгснөөс харахад сургалтын чанарт хэрэглэгчид төдийлэн таатай хандахгүй байна гэж үзэж болно. Түүнчлэн их дээд сургуулиудын сурталчилгаагаар өгөгдөж буй мэдээллүүд бодит байдлаасаа хэр их зөрүүтэйг судалж үзэхэд судалгаанд оролцогсдын 30 хувь нь бодитой, 47% нь маш их зөрүүтэй, 23 хувь нь зөрүүгүй гэж үзсэн

нь дээрх дүгнэлтийг давхар батлан харуулж байна. Харин оюутнууд сургалтын чанар, сурталчилгааны бодит байдлын талаар хэрхэн үнэлж байгааг хүснэгт 1- эд харуулав.

Хүснэгт 1

Сургуулиудын сургалтын чанар, сурталчилгааны бодит байдлын үр дүн

Үзүүлэлт		Улсын		Хувийн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Сургалтын чанарт өгсөн үнэлгээ	Сайн	284	92,51	101	20,49	385	48,12
	Дунд	23	7,49	217	44,02	240	30
	Муу			175	35,50	175	21,88
	Дүгнэж чадахгүй байна.						
	Дүн	307	100	493	100	800	100
Мэдэл-лийн бодит байдал	Маш их зөрүүтэй	18	5,86	301	61,05	319	39,88
	Бага зэрэг зөрүүтэй	189	61,56	161	32,66	350	43,75
	Зөрүүгүй	100	32,57	31	6,29	131	16,37
	Дүн	307	100	493	100	193	100

Эх сурвалж: Анхдагч судалгааны үр дүнг SPSS программыг ашиглан тооцоолсноор

Судалгаанд оролцогчдын 51% нь дээд боловсролын сургалтын чанарт тааруу үнэлгээг өгчээ. Тэгэхдээ энэхүү үнэлгээ сургуулийн өмчлөлийн хэлбэрээс хамааран ялгаатай байгаа бөгөөд төрийн өмчлөлийн сургуулиудын хувьд 92,5% нь сайн гэж үзсэн бол хувийн хэвшлийн сургуулиудын тухайд 79% нь дунд, муу гэсэн үнэлгээг өгсөн нь анхаарал татаж байна. Зах зээлд тараагдаж буй мэдээллийн хувьд суралцагчдын байр суурь тааруухан /нийт судалгаанд оролцогчдын 40%/ үнэлгээ өгснийг судалгаанаас харж болно. Энэ нь мөн сургуулиудын өмчлөлийн хэлбэртэй холбоотой ялгаатай байна.

Сургалтын чанарт хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйлүүд гэж үзсэн сургалтын орчин нөхцөл, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж, багшлах боловсон хүчний чадвар, чадамжийн талаар судалж үзэхэд дараах дүр төрх харагдаж байгаа юм. Эдгээр үзүүлэлтүүдийг хэрэглэгчийн үнэлгээний индексээр тооцож үзэхэд доорхи байдлаар үнэлэгдсэн байна.

- Сургалтын байр, тоног төхөөрөмж буюу сургалтын орчин 2,23
- Багшлах боловсон хүчний чадвар 2,18 буюу хамгийн чухалд тооцогдсон байна.

Бидний судалгаагаар сургалтын орчин нөхцөл, техник хэрэгслийн хүрэлцээ хангамж сайн байх нь сургалтын чанарт сайнаар нөлөөлдөг гэж

судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 78,38%, төгсөгчдын 99,75%, суралцагчдын 86,13%, ажил олгогчдын 58,33%, багш, удирдлагуудын 55,3% нь тус тус үзсэн. Харин өнөөдөр үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын байгууллагуудын орчин нөхцөлд хэрхэн үнэлгээ өгснийг судлаачийн бус дараах судалгааны үр дүнгээс харж болно.¹⁹ Үнэлгээг 1-5 баллаар авч үзжээ.

Хүснэгт 2

Сургалтын орчин нөхцөл, техник хэрэгслийн хүрэлцээ хангамжийн судалгаа /хувиар/

№	Үзүүлэлт	Үнэлгээ	Багш нар	Удирдлагууд	Оюутнууд
1	Хичээлийн анги танхимийн тохь тухтай байдал	1	7,2	2,2	15,7
		2	10,9	2,2	12,2
		3	41,3	21,7	41,1
		4	20	41,3	15,8
		5	20,6	32,6	15,2
2	Номын сангийн үйлчилгээ, хангамж	1	5,9	2,1	18,5
		2	12,6	8,5	19,3
		3	34,5	19,1	29,7
		4	26,8	51,1	17,8
		5	20,2	19,2	14,7
3	Компьютер, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж	1	6,6	2,1	31,6
		2	9,2	0	19,4
		3	22,1	23,5	22,3
		4	26,8	40,4	11,9
		5	35,3	34	14,8
4	Эрүүл мэнд, Хоолны газрын үйлчилгээ	1	21,7	2,1	23,7
		2	20,9	8,5	16,3
		3	28,7	31,9	26,7
		4	16,8	40,4	16,4
		5	11,9	17,1	16,9
5	Сургалтын материал, гарын авлагын хүрэлцээ, шинэлэг байдал	1	4,9	0	11,2
		2	8,9	0	11,9
		3	32,2	41,3	27,8
		4	31,7	43,5	24,8
		5	22,3	15,2	24,3

¹⁹ “Дээд боловсролын чанар-Бидний оролцоо, хамтын ажиллагаа” зөвөлгөөний эмхэтгэл. УБ. 2010 он

Эх сурвалж: Дээд боловсролын чанар-Бидний оролцоо, хамтын ажиллагаа” зөвөлгөөний эмхэтгэл. “Монгол улсын дээд боловсролын төлөв байдал” илтгэл, УБ, 2010/

Энэхүү судалгаанаас авсан сургалтын орчин нөхцөл, техник хэрэгслийн хүрэлцээ хангамжийн асуудалд багш, сургуулийн удирдлага, оюутнуудын өгсөн үнэлгээний дүнг ашиглан Хэрэглэгчдийн үнэлгээний индексийг тооцож үзвэл:

- Хичээлийн анги танхимийн тохь тухтай байдалд өгсөн багш нар 3,36, удирдлагууд 3,98, оюутнууд 3,03
- Номын сангийн үйлчилгээ, хангамжийн асуудалд багш нар 3,43, удирдлагууд 3,77, оюутнууд 2,99
- Компьютер, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийн асуудалд багш нар 3,75, удирдлагууд 4,04, оюутнууд 2,59
- Эрүүл мэнд, Хоолны газрын үйлчилгээнд багш нар 2,79, удирдлагууд, 3,62, оюутнууд 2,86,
- Сургалтын материал, гарын авлагын хүрэлцээ, шинэлэг байдалд багш нар 3,58, удирдлагууд 3,74, оюутнууд 3,39 гэсэн үнэлгээ тус тус өгчээ.

Дээрх хоёр судалгааны дүнг нэгтгэн харвал сургалтын орчин нөхцөлтэй холбоотой асуудлуудад оюутан, багш нарын хүсэл сонирхол ямагт давамгайлж, тэдний хувьд илүү тохилог орчин, илүү их хүрэлцээ хангамжийг шаарддаг нь тодорхой байна.

Харин дээд боловсролын байгууллагын *багшлах боловсон хүчний чанар, чадварын* талаарх хариултын үр дүнг судалгааны объект бүрээр задлавал эцэг эхчүүдийн 66,88% , суралцагчдын 88,63%, төгсөгчдийн 93% , ажил олгогчдын 52,33%, багш нарын 55,7% нь өрсөлдөх чадварын гол ач холбогдолтой үзүүлэлт гэж үзжээ. Багшлах боловсон хүчний чадвар чадамжийн асуудлыг өнөөгийн түвшинд бид багш нарын эрдмийн зэрэг цол, эрдэм шинжилгээ судалгааны ажлын цар хүрээ, үр дүнгээр дүгнэж хардаг.

“Дээд боловсролын чанар-Бидний оролцоо, хамтын ажиллагаа” зөвөлгөөн дээр БСШУ-ны сайд Ё.Отгонбаярын тавьсан “Дээд боловсролын хөгжлийн өнөөгийн байдал, зорилт” илтгэлээс үзвэл 2010 оны байдлаар манай нийт багш нарын дотор эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувийн жин үнэхээр бага, доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувь дөнгөж 22.4% ²⁰байна. Түүнчлэн БСШУЯ-ны мэргэжилтнүүдийн 30 их дээд сургуулийн 470 багшаас авсан судалгааны үр дүнгээс харвал судалгаанд оролцсон багш нарын 40 гаруй хувь нь судалгаа шинжилгээний ажил хийдэггүй гэсэн хариулт өгчээ. Судалгаанд оролцсон багш нарын

²⁰ БСШУ-ны сайд Ё.Отгонбаярын тавьсан “Дээд боловсролын хөгжлийн өнөөгийн байдал, зорилт” илтгэл, 2010

48,9 хувь нь сургалтын ажилд цаг их зардаг учир эрдэм шинжилгээний ажил хийх боломж муутай байдаг гэж үзсэн байна.²¹ Энэ нь багшлах боловсон хүчний чанар, чадавхийн асуудалд их дээд сургуулиуд онцгой анхаарах шаардлагатай байгааг харуулж буй хэрэг юм.

Судалгаанд оролцсон багш нарын ажилдаа хандах хандлага, сургалтын чанарт өгсөн үнэлгээг хүснэгт 3 – аар харуулав.

Хүснэгт 3

Багш нарын сэтгэл ханамж, сургалтын чанарт өгсөн үнэлгээ

Үзүүлэлт		Улсын		Хувийн		Гадаадын хөрөнгө оруулалттай		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Сэтгэл ханамж	Маш их сэтгэл хангалуун байна.	87	88,78	49	25,39	6	66,67	142	47,33
	Зөв сонголт болсон	11	11,22	62	32,12	3	33,33	76	25,33
	Сэтгэл дундуур байдаг		0,00	82	42,49		0,00	82	27,33
	Дүн	98	100	193	100	9	100	300	100
Сургалтын чанарт өгсөн үнэлгээ	Сайн	67	68,37	55	28,50	7	77,78	129	43,00
	Дунд	31	31,63	89	46,11	2	22,22	122	40,67
	Муу		0,00	49	25,39		0,00	49	16,33
	Дүгнэж чадахгүй байна.		0,00		0,00		0,00	0	0,00
	Дүн	98	100	193	100	9	100	300	100
Санаа зовоодог асуудлууд	Сургалтын чанар	13	13,27	48	24,87		0,00	61	20,33
	Элсэгчийн мэдлэг чадварын түвшин	22	22,45	9	4,66	5	55,56	36	12,00
	Сургалтын орчин нөхцөл	5	5,10	74	38,34	1	11,11	80	26,67
	Багшлах хүчний чадвар, чадамж	11	11,22	56	29,02	1	11,11	68	22,67
	Эрдэм шинжилгээ судалгааны ажил	47	47,96	6	3,11	2	22,22	55	18,33
	Дүн	98	100	193	100	9	100	300	100

Эх сурвалж: Анхдагч судалгааны үр дүнг SPSS программыг ашиглан тооцоолсноор

²¹ “Дээд боловсролын чанар-Бидний оролцоо, хамтын ажиллагаа” зөвөлгөөний эмхэтгэл. УБ. 2010 он

Эндээс харвал улсын сургуулийн багш нарын сэтгэл ханамж өндөр, харин хувийн хэвшлийн их дээд сургуульд ажиллаж буй багш нарын 42% нь ажил мэргэжилдээ сэтгэл хангалуун бус байдаг гол шалтгааныг цалин, ажлын ачаалалтай холбон тодорхойлжээ. Харин судалгаанд оролцсон багш нарын дийлэнх нь өнөөгийн сургалтын чанарт санаа зовж байгаагаа илэрхийлсэн ба цаашид сургалтын орчин нөхцлийг сайжруулах нь зүйтэй гэсэн байна.

Их дээд сургуулиудын өрсөлдөх чадварыг тодорхойлох бусад үзүүлэлтүүдийг авч үзвэл:

Сургалтын стандарт, хичээлийн хөтөлбөр сайн байх нь сургалтын чанарт нөлөөлөх чухал хүчин зүйлүүдийн нэг мөн. Энэ талаар судалгаанд оролцсон эцэг, эхчүүдийн 11,25%, суралцагчдын 16,5%, төгсөгчдийн 23,75%, ажил олгогчдын 18%, багш нарын 43,3% нь буюу нийт судалгаанд оролцогчдын 20% нь сургалтын үйл явц, хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө сайн байх нь сургалтын байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөөтэй хэмээн үзсэн. Сургалтын стандарт хичээлийн хөтөлбөрийн агуулгад анхаарах хэрэгтэй байгааг төрийн өмчийн сургуулиас судалгаанд оролцсон оролцогчдын 30%, хувийн хэвшилд суралцагчдын 25%, гадаадад төгссөн болон ГХО-тай сургууль төгсөгчдийн 50% нь тодорхойлсон байна. Хэрэглэгчийн үнэлгээний индексээр тооцож үзэхэд 0,52 гэсэн үнэлгээ авсан нь харьцангуй доогуур үнэлгээ хэдий ч сургалтын чанар болон өрсөлдөх чадварт нөлөөлөхүйц үзүүлэлт нь тодорхой юм.

Өрсөлдөх чадварын дараагийн нэг үзүүлэлт нь *сургуулийн түүхэн замнал, оршин тогтносон хугацаа* байлаа. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 21,4 хувь, суралцагчдын 39,13 %, төгсөгчдийн 13,13%, ажил олгогчдын 60,67%, сургуулийн удирдлага, багш нарын судалгаанд оролцогчдын 62,7 хувь нь дээд боловсролын байгууллагын өрсөлдөх чадварыг тодорхойлох гол үзүүлэлтээр тухайн сургуулийн сургалт явуулсан ажлын туршлага, оршин тогтносон хугацаа гэж тодорхойлсон. Сургуулийн түүхэн замнал, оршин тогтносон хугацаа буюу сургуулийн нэр хүндийг хэрэглэгчийн үнэлгээний индексийн үнэлгээгээр үнэлбэл 0,95 гэсэн үнэлгээ авсан байна.

Түүнчлэн сургуулийн нэр хүндийг тодорхойлдог нэг үзүүлэлт бол өнөөдөр *сургуулийн өмчийн хэлбэр* болохыг бид дараахь судалгааны үр дүнгээс харж болно. /зураг 2/ Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин өмчийг чөлөөлсөн явдал нь хувийн хэвшлийн их дээд сургуулиуд үүсэн хөгжих нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд эдгээр сургуулийн хувьд улсын сургуулиудтай харьцуулахад оршин тогтносон хугацаа нь харьцангуй богинохон. Төрийн өмчийн сургуулиуд 40-80 гаруй жилийн түүхтэй байхад хувийн хэвшлийн сургуулиудын дээд тал нь дөнгөж 20 жилийн хугацаанд материаллаг баазаа бэхжүүлсэн байна.



Эх үүсвэр: Анхдагч судалгааны үр дүнг SPSS программыг ашиглан тооцоолсноор, 2011

Сургуулиа төгсөөд ажилд орж байгаа байдлыг авч үзвэл нэр хүнд сайтай дээд сургууль төгсөгчид ажилд орох нь харьцангуй хурдан байхад хувийн их дээд сургууль төгсөгчдийн хувьд дийлэнх хувь нь хожуу эсвэл гол төлөв мэргэжлийн бус ажил хийдэг нь судалгаанаас харагдав. Мөн судалгаанаас ажил олгогчдын 42,67 хувь нь улсын сургууль төгсөгчдөөс хүний нөөцөө бүрдүүлэхэд анхаардаг гэж үзсэн байна.²² Энэ сургуулиудын сургалтын чанартай холбоотой нь мэдээж хэрэг.

Дэлхийн жишгээр бол дээд боловсролын өрсөлдөх чадавхийг тодорхойлохдоо дараах хэдэн үзүүлэлтийг анхаардаг байна. Үүнд:

- Нобелийн шагналтны тоо
- Математик ба байгалийн шинжлэх ухаанд нээлт хийсэн байдал
- Шинэ технологи бүтээж, патент, лиценз эзэмшсэн байдал
- Судлаачдын нь бүтээлийг олон улсын нэр хүндтэй сэтгүүлд иш татсан байдал г.м.

Глобал өрсөлдөөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд эяаууд нь манай орны их, дээд сургуулиудын чанар чансаа дэлхийн жишигт ойртуулахад цаашид анхаарвал зохих чухал үзүүлэлтүүд болох нь гарцаагүй. Зөвхөн судлаачдын нь бүтээлийг олон улсын нэр хүндтэй сэтгүүлд иш татсан байдлыг судалж үзэхэд 2009 оны байдлаар АНУ-ын судлаачдыг 3876 удаа, Японы

²² Анхдагч судалгааны үр дүнг SPSS программыг ашиглан тооцоолсноор, 2011

судлаачдыг 249 удаа иш татсан бол Малайз, Тайланд, Вьетнам зэрэг бага буурай орны судлаачдын бүтээлээс иш татах асуудал энэ онд дурдагдаагүй байна. Мөн 2009 оны байдлаар өндөр хөгжилтэй орнуудад хэрэглээнд оруулсан гадаадын ба дотоодын патентийн харьцаа 3:1 байхад буурай орнуудад 694:1 байжээ.²³ Харин Монгол оронд дээрх үзүүлэлтийн аль аль нь доогуур түвшинд байдаг.

Харин бид эдгээр үзүүлэлтийг судалгаанд оролцогсод хэрхэн авч үзэхийг анхаарсан юм. Үүнд:

Судлаачдын нь бүтээлийг олон улсын сэтгүүлд иш татсан байдал. Нийт судалгаанд оролцогчдын 15,57 % нь эрдэмтэн багш нарынх нь бүтээл олон улсын сэтгүүлд хэвлэгддэг байхыг чухал гэж үзсэн. Судалгаанд оролцсон эцэг эхчүүд, суралцагчдын 10% , төгсөгчдийн 19%, ажил олгогчдын 26%, багш нарын 27% нь тус тус энэхүү хариултыг сонгосон байна. Энэхүү хариултыг сонгосон төгсөгчид бүгд /152/ гадаадад их дээд сургууль төгссөн хүмүүс байсныг энд дурьдах нь зүйтэй болов уу. Гадаадын нэр хүнд бүхий их дээд сургуулийн хувьд багшлах боловсон хүчний эрдэм судлалын ажил хийгээд бүтээлийг олны хүртээл болгох дэлхийн хэмжээнд таниулахад ихээхэн анхаардаг байна. Харин багш нарын хувьд 84% буюу 68 багш нь төрийн өмчийн их дээд сургуулийн багш нар байв. Хэрэглэгчийн үнэлгээний индексээр үнэлэхэд 0,37 гэсэн үнэлгээ авсан. Эндээс бид сургалтын үйл ажиллагааг зөвхөн элсэгчийг төгсөгч болгох үйл явц гэж үзэж байдгаас гадна цаашид багш нар эрдэм шинжилгээний ажил, бүтээлд илүү төвлөрөх, судлаачийн бүтээлийг олон улсын хэмжээнд хүртээл болгоход багагүй анхаарах хэрэгтэй нь харагдаж байна.

Шинэ технологи бүтээж, патент лиценз эзэмшсэн байдал. Судалгаанд оролцогчдын 10% нь энэхүү хариултыг сонгосон. Эх үүсвэр тус бүрээр хариултуудыг задлавал эцэг эхчүүдийн 5,38%, суралцагчдын 8,13% , төгсөгчдийн 10,88%, ажил олгогчдын 24%, багш нарын 10% нь өрсөлдөх чадварыг тодорхойлох үзүүлэлтээр тухайн сургуулийн эрдэмтдийн шинэ технологи бүтээж патент, лиценз эзэмшсэн байдал гэж үзсэн байна. Энэхүү хариултыг өгсөн төгсөгчдийн 69% буюу 60 мэргэжилтэн нь гадаадын их дээд сургууль төгссөн, багш нарын 86% буюу 26 оролцогч нь улсын их дээд сургуулийн багш нар байв. Энэчилэн сургуулиудын багш, эрдэмтдийн шинэжлэх ухаанд нээлт хийсэн байдал, төгсөгчид нь алдар цуутай байх гэдэг үзүүлэлтүүдийг судалгаанд оролцогчдын 12,2 % нь өрсөлдөх чадварт нөлөөтэй гэж үзсэн. Хэрэглэгчийн үнэлгээний индексийн үнэлгээ нь 0,29 байгаа нь доогуур үзүүлэлт боловч зайлшгүй анхаарах ёстой үзүүлэлт гэдгийг давхар нотлож байгаа хэрэг юм.

Хэдийгээр судалгаанд оролцогчдын тодорхой хувь нь дээрх дэлхийн жишиг үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч байгаа боловч манай орны их дээд сургуулиудын багш, судлаачдын бодит статистиктай харьцуулбал энэ нь

²³ World Bank 2009. World Bank Indicators

үнэхээр хоцрогдролтой явдаг. Өмнө их дээд сургуулиудын нийт багш нарын тоонд эрдмийн зэрэгтэй багш нар туйлын хангалтгүй байр суурьтай байгааг дурдсан. Мөн нийт багш нарын тоонд эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гүйцэтгэж байгаа ажилтны хувийн жин маш бага буюу 0,11% байдаг. Эрдэм шинжилгээний ажлын зардал их дээд сургууль, коллежийн нийт урсгал зардлын дөнгөж 1%-ийг эзлэж байгааг²⁴-аар энэ нь харагдана. Энэ бүхэн нь манай их дээд сургуулиуд сургалтын чанарыг дээшлүүлэх, суралцагсдын хүлээлтэд хүрэхийн тулд багшлах боловсон хүчний эрдэм шинжилгээ судалгааны ажилд ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэйг харуулж байна.

Өөрөөр хэлбэл багшлах боловсон хүчний чадвар гэдэг нь өрсөлдөх чадварыг тодорхойлох гол үзүүлэлт бол багш нарын эрдэм судлалын ажил хийгээд тэдгээрийг олон улсын хэмжээнд гаргаж нийтийн хүртээл болгох явдал одоо бидний хийх гол ажил болоод байгааг энэхүү судалгааны үр дүн харуулж байна. Дээд боловсролын тухай Монгол Улсын хуулийн 4.2, 4.3-т “Их сургууль нь шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр суурь ба хавсарга судалгаа явуулдаг, бакалавр, магистр, докторын сургалт эрхэлдэг, үйлдвэр, үйлчилгээний бааз лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байна. Дээд сургууль нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж дипломын болон бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага мөн.” гэж заасан байдаг. Эндээс бид дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг зөвхөн элсэгч төгсөгчийн хүрээнд бус хуулинд заагдсны дагуу БАГШ-ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ-ЭРДМИЙН БҮТЭЭЛ гэсэн нэгдмэл систем дотор зайлшгүй авч үзэх цаг хугацаа болжээ. Ингэж чадсан их дээд сургуулиуд зөвхөн дотооддоо бус дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болох юм.

Бид мэдлэгийг үйлдвэрлэх хамгийн гол хөдөлмөрийн хэрэгсэл бол багшлах боловсон хүчин гэдэгтэй санал нэгдэж байгаа нь тодорхой. Харин нөгөөтэйгүүр багш нарыг хамгийн хурдан чадваржуулан дэлхийн хөгжлийн чиг хандлагыг урьдчилан тодорхойлж түүнд нийцсэн мэдлэг мэдээллийг суралцагчдад олгох, төгсөгчид нь харин орчин үетэйгээ алхаа нийлүүлсэн тухайн салбарынхаа эрэлт хэрэгцээг хангахуйц мэргэжилтэн байхыг цаг үе биднээс шаардаж байна. Иймээс өнөөдрийн сургалтын чанарыг дээшлүүлэхэд аль болох академик сургалтаас татгалзан оюутнуудаа бизнесийн мөн чанартай танилцуулан дадлагад суурилсан сургалтанд шилжих, багш нар өөрсдөө тухайн салбарынхаа судлаач эрдэмтэн байх нэн шаардлагатай байна.

²⁴ Шихихутаг ХЗДС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор доктор профессор Ч. Даваадашийн илтгэл, 2010 он

Дүгнэлт

- ✚ Дээд боловсролын байгууллага нь нийгмийн үйлчилгээний бизнес эрхлэдэг байгууллагын хувьд ОРЦ-ЯВЦ-ГАРЦ гэсэн тогтолцоо бүхий систем гэж үзэх нь зүй. Энэ утгаараа ЭЛСЭГЧ-СУРГАЛТ-ТӨГСӨГЧ гэж томъёолдог.
- ✚ Монгол улсын цаашдын хөгжил дэвшлийн эх сурвалж нь “ХҮН”, “ХҮНИЙ ХӨГЖИЛ”, “БОЛОВСРОЛ”, “БОЛОВСРОЛЫН ЧАНАР” юм. Эндээс дээд боловсролын өрсөлдөх чадварын гол үзүүлэлт бол сургалтын чанарын асуудал болно.
- ✚ Цаашид сургалтын чанарын сайжруулахын тулд прагматик хандлага давамгайлсан сургалтанд шилжих хэрэгтэй бөгөөд аль болох дадлага, туршлага хуримтлуулсан бизнесийнхээ мөн чанарыг ойлгодог, юу хийхээ сайн мэддэг мэргэжилтэнг төгсгөн гаргахыг зах зээл шаардах болжээ. Энэ ч утгаараа багш бол онолын мэдлэгийн дамжуулагч биш өөрөө туршин шийдэгч, өөрийн салбартаа мэргэшсэн мэргэжилтэн байж чадснаар сургуулийн өрсөлдөх чадварыг бүрдүүлж чадна.
- ✚ Монгол улсын боловсролын хуулинд заагдсны дагуу дээд боловсролын байгууллага нь эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага гэдэг утгаараа БАГШ-ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ-ЭРДМИЙН БҮТЭЭЛ гэж томъёолж болно. Эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг манай дээд сургуулиудын хүрээнд энэ тогтолцоо нь алдагдаад байна гэдгийг сануулах нь зүйтэй.

Ном зүй:

1. Боловсролын тухай Монгол Улсын хууль. УБ. 2002
2. Дээд боловсролын тухай Монгол Улсын хууль. УБ. 2002
3. Н. Бэгз. Глобальчлалын үеийн Монголын боловсролын онол аргазүй. УБ. 2002
4. Н. Наранчимэг, Э. Төгөлдөр. Боловсролын удирдлага. УБ 2010
5. “Дээд боловсролын сургалтын байгууллагын менежментийг боловсронгуй болгох нь” сэдэвт семинарын материал. УБ. 2002
6. “Дээд боловсролын чанар-бидний оролцоо хамтын ажиллагаа” сэдэвт ажил төрлийн зөвөлгөөний илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2010
7. World Bank 2009. World Bank Indicators
8. Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө
9. www.blogger.com.O.Batkhuu.blog АНУ-ын боловсролын систем.
10. www.may.gov.mn Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого
11. М. Булгантамир. Дээд боловсролын байгууллагын өрсөлдөх чадварын үзүүлэлтийн талаархи хэрэглэгчийн анхдагч судалгааны үр дүн 2011 он.